

БАТЛАВ.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУДАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.ТӨМӨРХҮҮ

АГААР, ХӨРС, УСНЫ БОХИРДОЛ БУУРУУЛАХ АЖЛЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР
ГЭР ХОРООЛЛЫН ИРГЭДИЙН ОРОЛЦООНД СУУРИЛСАН ИНЖЕНЕРИЙН
ХАНГАМЖ, ДЭД БҮТЦИЙН ТУРШИЛТЫН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 11 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 2024/10

Улаанбаатар хот

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Төсөл боловсруулах үндэслэл	<p>-Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаарх хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах"</p> <p>-УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын Зорилт 3.2 дугаар хэсэгт:</p> <ul style="list-style-type: none">- Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. <p>-УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.3.7-т:</p> <ul style="list-style-type: none">- 1.1.3.7.Гэр хорооллын бүсэд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон, пассив барилгын стандарт болон ногоон санхүүжилтийн шаардлага хангахуйц бие даасан инженерийн шийдэлтэй загвар хорооллыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн барьж байгуулна.- 1.1.2.11.Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох дулаалгын төслийг хэрэгжүүлнэ.- 3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. <p>-Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 3/дах заалт "байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт хугацааны ногоон санхүүжилтийн арга</p>

		<p>хэрэгслийг нэвтрүүлэх;”, 2 дох хэсгийн 2/ дугаар заалт “агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м2-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.”</p> <p>- Засгийн газрын 2023 оны “иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 483 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 1.3-т заасан “Миний амины орон сууц-иргэний амины орон сууц шинээр барих, эсхүл одоо амьдарч байгаа амины орон сууцныхаа нөхцөлийг сайжруулах, дэд бүтцэд холбох зэрэг орон сууцны таатай нөхцөлийг бүрдүүлэх;”</p>
	Холбогдох хууль тогтоомж	<ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль - Монгол Улсын 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай хууль; - Газрын тухай хууль; - Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Геодези, зураг зүйн тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Усны тухай хууль; - Орон сууцны тухай; - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай;
2	Төслийн зорилго	Иргэдийн бүлгийн оролцоонд суурилсан инженерийн хангамж, дэд бүтцийг байгуулах ажлыг тодорхой байршилд гүйцэтгэж, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, гэр хорооллын иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах арга хэмжээг дэмжсэн загвар төслийг бий болгох;
3	Хамрах хүрээ	Улаанбаатар хотын гэр хорооллын бүс 10- дээш айл өрх
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 40 хоног / Дөчин/ хоног
5	Гүйцэтгэх ажлын үе шат, иж бүрдэл	<p>Агаар, хөрс, усны бохирдол бууруулах ажлыг дэмжих чиглэлээр гэр хорооллын иргэдийн оролцоонд суурилсан инженерийн хангамж, дэд бүтцийн туршилтын төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <p>1. Өнөөгийн нөхцөл байдлыг үнэлсэн байдал</p> <ul style="list-style-type: none"> - Орчны нөхцөл байдал (төв замтай холбогдсон байдал, нийгмийн дэд бүтцийн хүртээмж, үерт өртөх байдал г.м) - Барилга байгууламж (дулаан алдагдал, тэсвэрлэх чадвар) - Ариун цэврийн байгууламж г.м <p>2. Төсөл боловсруулах үе шат</p> <ul style="list-style-type: none"> - Суурь судалгааны өгөгдөл, мэдээлэл, байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зурагт үндэслэн инженерийн шугам сүлжээний техникийн зураг төсөл, гүйцэтгэл;

		<ul style="list-style-type: none"> - Техникийн шийдэл, тоног төхөөрөмжийн сонголт, эдийн засгийн тооцоолол, төслөөр гүйцэтгэх ажлын ерөнхий төлөвлөгөө - Хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах; <p>3. Төсөл хэрэгжүүлэх үе шат</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын даалгавартай нарийвчлан танилцаж, төслийн ажлын иж бүрдлийг ойлгож, үе шатны ажлын төлөвлөгөөтэй танилцаж, зөвшилцөх; - Инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн угсралтын ажлыг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх; - Туршилтын төслийн ажлыг тайлангийн хамт хүлээлгэн өгөх; <p>4. Төслийг хүлээлгэн өгөх, ашиглалтад оруулах, гэрээ дүгнэх үе шат</p> <ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэлийн зураг төсөл, тайлан, шугам сүлжээг ашиглалтад оруулах;
6	Ажлын үр дүн	Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой суурь судалгаа, тооцооллыг бүрэн хийж, холбогдох төлөвлөгөө, зураг төслийн дагуу гэр хорооллын иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн дэвшилтэд технологи бүхий инженерийн дэд бүтцийг ашиглалтад оруулах;
7	Техникийн шаардлага	<p>1. Бохир ус. 10 айлд зориулсан 10м³ багтаамжтай септик систем. (1. MNS EN 12566-1 : 2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж.</p> <p>1-р хэсэг: Угсармал септик 2. MNS EN 12566-2 : 2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж.</p> <p>2-р хэсэг: Хөрсөөр шүүрүүлэх систем. 3. MNS EN 12566-3 : 2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж.</p> <p>3-р хэсэг: Угсармал болон газар дээр нь угсарсан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж 4. MNS EN 12566-4 : 2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж.</p> <p>4-р хэсэг: Угсардаг иж бүрдлийг ашиглан газар дээр нь угсарсан септик 5. MNS EN 12566-5 : 2011, 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж.</p> <p>5-р хэсэг: Урьдчилсан цэвэрлэгээ хийсэн бохирыг шүүх шүүлтүүрийн систем) Ф100-Ф150 PVC шугам, урт – 380м</p> <p>2. Цэвэр ус. 10 айлд зориулсан цэвэр усны урьдчилсан дулаалгатай PEX шугам. Ф20-Ф32, урт-550м. (MNS GOST R 58097:2023, MNS EN 15632-1:2023, MNS EN 489-1:2023, MNS EN 15632-2:2023) 6м³ багтаамжтай цэвэр усны ган сав.</p> <p>3. Гадна дулаан. 10 айлд зориулсан дулааны эх үүсвэр 50-100квт/цаг хүчин чадал бүхий хатуу түлшний зуух. Гадна дулааны урьдчилсан дулаалгатай PEX шугам.</p>

		<p>Ф20-Ф32, урт-550м. (MNS GOST R 58097:2023, MNS EN 15632-1:2023, MNS EN 489-1:2023, MNS EN 15632-2:2023) Халаалтын зуухны барилга сендвич Урт-6м, Өргөн -4м, Өндөр- 3м.</p> <p>4. Гадна цахилгаан. Зуухны барилгын цахилгаан татах. 8квт. Ойролцоох эх үүсвэрээс</p> <ul style="list-style-type: none"> - Дэвшилтэд технологи бүхий инженерийн дэд бүтцийн өөр шийдэл санал болгож болно. - Төслийн талбайд хамрагдаж байгаа айл өрхийн эзэмшил газрын хил зааг дотор шугам сүлжээг төлөвлөх; / Хашаан дотор/ <p>Төслийн ажил нь дараах барилгын норм, нормативын шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл /БНБД 11-07-19/ барилгын норм, дүрэм; 2. "Барилга байгууламжийн геодезийн ажил" /БНБД 11-08-23/ барилгын норм, дүрэм; 3. "Агаар, сансрын зураглалын ажил" /БНБД 11-14-23/ барилгын норм, дүрэм; 4. "1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил" /БД 11-106-08/ 5. Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил /БД 11-115-16/; 6. "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016
8	Ажлын хяналт шалгалт	Гэрээгээр тохиролцоно.
9	Ажил хүлээлгэж өгөх	-Гүйцэтгэх ажлын үе шат, иж бүрдлийн дагуу шугам сүлжээг ашиглалтад оруулах; -Ажлын тайлан- 3 хувь цаасан болон цахим хэлбэрээр; -Ажлын үйл явцын видео зураглал, танилцуулга
10	Захиалагч байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
11	Гүйцэтгэгч	Инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт, барилга байгууламжийн инженерийн суурь судалгаа, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах үйл ажиллагааг явуулах тусгай, тусгай зөвшөөрөлтэй, 5 болон түүнээс дээш жилийн ажлын туршлагатай хуулийн этгээд болон хуулийн этгээдийн түншлэл
12	Санхүүжилт, эх үүсвэр	300.000.000 төгрөг / Гурван зуун сая/, ХББОСС-ын төсвийн багц
13	Онцгой нөхцөл	- 10 дээш айл хамтран бүлэг байгуулж зөвшилцөх бөгөөд цаашид төслийн ашиглалтыг иргэдийн бүлэг өөрөө хариуцах,

		- Нөхцөл байдлаас шалтгаалан даалгаварт тусгаагүй ажлыг гэрээний нөхцөлөөр тодорхойлно.
--	--	---

ХЯНАСАН:

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Э.БАТБОЛД

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ САНХҮҮЧ



Т.МӨНГӨНЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ САНХҮҮ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ



Ж.ОРХОНБАЯР

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ




Г.ГОЁСАЙХАН

НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

С.БОЛОО

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



А.ЭНХНАРАН